



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН, ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААН, ЭРСДЭЛТ ХУЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН ШАТАЛСАН СУДАЛГАА, МОНГОЛ УЛС-2013 ОН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

Зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, уушгины архаг бөглөрөлтөт өвчин (багтраа)-г хамтатган Халдварт бус өвчин (ХБӨ) гэж нэрлэдэг. Түгээмэл тохиолдох анхдагч эрсдэлт хүчин зүйлс нь завсрын буюу хоёрдогч эрсдэлт хүчин зүйлийг үүсгэж, улмаар хүн амыг ХБӨ-өөр өвчлөхөд хүргэдэг байна.

Халдварт бус архаг өвчний шалтгаан

Нийгэм эдийн засаг, соёл, улс төр, орчны нөлөө	Анхдагч эрсдэлт хүчин зүйл (Залруулан өөрчлөх боломжтой)	Завсрын эрсдэлт хүчин зүйлс	Зонхилон тохиолдох ХБӨ
Даяаршил	Зохисгүй хооллолт	Таргалалт	Зүрхний өвчин
Хотжилт	Хөдөлгөөний хомсдол	Төвийн таргалалт	Харвалт
Хүн амын насжилт	Архины хэрэглээ	Цусны даралт ихсэлт	Хавдар
	Тамхины хэрэглээ	Цусан дахь сахарын ихсэлт	Чихрийн шижин
	Анхдагч эрсдэлт хүчин зүйл (Залруулан өөрчлөх боломжгүй)	Цусан дахь өөх тосны ихсэлт	Уушгины архаг бөглөрөлтөт өвчин
	Нас		
	Удамшил		

СУДАЛГААНЫ ТОЙМ

ХБӨ, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгааг ДЭМБ-ын шаталсан судалгааны арга, аргачлалын дагуу Улаанбаатар хотын 8 дүүрэг, 21 аймгийг хамруулан үндэсний түвшинд 2013 онд зохион байгуулсан. Судалгааг ХБӨ, Осол гэмтлийн нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тогтоох, “ХБӨ-өөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр, Монголын Мянганы Сорилтын Сан (ММСС)-гийн “Эрүүл мэндийн төсөл”-ийн үр дүн, үр нөлөөг үнэлэх зорилгоор хийв. МУ-ын 15-64 насны 6013 хүнээс цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийж, судалгааны үр дүнг тооцсон болно.





Зураг 1. Судалгааны түүврийн нэгжийн байршил



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН, ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААН, ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН ШАТАЛСАН СУДАЛГАА, МОНГОЛ УЛС-2013 ОН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

ТАМХИ, АРХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Монгол Улсын 15-64 насны хүн амын дунд (95% ИХ)	Бүгд (N=6013)	Эрэгтэй (N=2719)	Эмэгтэй (N=3294)
Шатлал 1. Тамхины хэрэглээ			
Тамхи татдаг хүн амын эзлэх хувь	27.1 (25.2-29.0)	49.1 (46.5-51.8)	5.3 (4.0-7.0)
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	19.7 (19.2-20.3)	19.1 (18.6-19.7)	25.9 (23.6-28.2)
Тамхи татсан дундаж хугацаа (жилээр)	20.5 (19.5-21.5)	21.2 (20.2-22.1)	14.4 (11.1-17.6)
Өдөрт татдаг үйлдвэрийн тамхины дундаж тоо	10.0 (9.2-10.8)	10.3 (9.5-11.2)	6.4 (5.5-7.4)
Дам тамхидалт (орон гэрт)	40.9 (37.9-44.0)	36.0 (32.5-39.7)	45.8 (42.4-49.1)
Дам тамхидалт (ажлын байранд)	25.5 (22.7-28.5)	31.9 (28.4-35.5)	19.4 (22.7-28.5)
Шатлал 2. Архи, согтууруулах ундааны хэрэглээ			
Сүүлийн 1 жилд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын эзлэх хувь	64.6 (60.3-68.6)	74.5 (71.5-77.2)	54.8 (47.7-61.7)
Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын эзлэх хувь	36.3 (33.3-39.3)	48.8 (46.0-51.5)	24.1 (20.2-27.9)
Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн тоо (давтамж)	3.6 (2.9-4.4)	4.3 (3.3-5.2)	2.4 (1.9-2.9)
Сүүлийн 1 сард, нэг удаад хэрэглэсэн архи, согтууруулах ундааны стандарт уулт (1 стандарт уулт=архи 25 мл, шар айраг 330 мл, дарс 100 мл)-ын дундаж хэмжээ	9.0 (8.3-9.6)	10.8 (9.9-11.8)	5.2 (4.8-5.6)
Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундааг хэтрүүлэн (нэг удаад ≥6 стандарт уулт) хэрэглэсэн хүн амын эзлэх хувь	23.5 (21.2-25.7)	37.5 (34.4-40.6)	9.7 (8.0-11.7)





Гол мэдээлэл:

- МУ-ын 15-64 насны нийт хүн амын 27.1 хувь, эрэгтэйчүүдийн тал (49.1%) орчим хувь нь тамхи хэрэглэдэг, энэхүү үзүүлэлт нь 2005 оноос хойш төдийлөн буурахгүй байна.
- Архи, согтууруулах ундааны хэрэглээ буурахгүй, нийт хүмүүсийн 64.6 хувь сүүлийн 1 жилд согтууруулах ундаа хэрэглэсэн, 1 удаад хэрэглэх хэмжээ нь 2009 оны түвшингээс нэмэгдсэн байв.



ЖИМС, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ БА ХӨДӨЛГӨӨНИЙ ИДЭВХ

Монгол Улсын 15-64 насны хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Шатлал 1. Жимс, ногооны хэрэглээ			
Ердийн 7 хоногт жимс хэрэглэсэн өдрийн тоо	1.1 (1.0-1.2)	0.9 (0.7-1.0)	1.3 (1.2-1.5)
Хоногт хэрэглэсэн жимсний дундаж хэмжээ (1 нэгж=80 г), нэгжээр	0.4 (0.4-0.5)	0.3 (0.3-0.4)	0.5 (0.4-0.6)
Ердийн 7 хоногт ногоо хэрэглэсэн өдрийн тоо	4.5 (4.2-4.9)	4.5 (4.1-4.9)	4.6 (4.2-4.9)
Хоногт хэрэглэсэн ногооны дундаж хэмжээ (1 нэгж=80 г), нэгжээр	1.0 (0.9-1.1)	1.0 (0.9-1.1)	1.1 (1.0-1.2)
Хоногт хэрэглэсэн жимс, ногооны дундаж хэмжээ (1 нэгж=80 г), нэгжээр	1.5 (1.3-1.6)	1.3 (1.2-2.5)	1.6 (1.4-1.7)
Хоногт дунджаар 5 нэгжээс бага жимс, ногоо хэрэглэсэн хүн амын эзлэх хувь	96.4 (95.3-97.2)	97.1 (96.1-98.1)	95.7 (94.5-96.8)
Шатлал 1. Хөдөлгөөний идэвх			
Хөдөлгөөний хомсдолтой хүн амын эзлэх хувь (7 хоногт < 600 MET минут)	22.3 (18.4-26.7)	21.3 (17.3-25.3)	23.2 (18.3-28.2)
Эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөний талаарх ДЭМБ-ын зөвлөмжийг биелүүлээгүй хүн амын эзлэх хувь	18.3 (14.5-22.2)	16.9 (13.3-20.4)	19.7 (15.0-24.4)
Хоногт идэвхтэй хөдөлгөөн хийхэд зарцуулдаг дундаж голч хугацаа	105.7 (31.4-300.0)	114.3 (36.4-317.1)	95.7 (28.6-274.3)
Биеийн хүч их шаардсан хөдөлгөөн хийдэггүй хүн амын эзлэх хувь	66.6 (63.4-69.8)	57.6 (53.8-61.3)	75.5 (72.3-78.6)



Гол мэдээлэл:



- Хүн амын дийлэнх (96.4%) нь жимс, ногоог хоногт 5 нэгжээс бага буюу ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс бага хэрэглэдэг, 2005 оны түвшингээс нэмэгдээгүй харин ч буурсан байв.
- Таван хүн тутмын нэг (18.3%) нь эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөн хийх ДЭМБ-ын зөвлөмжийг биелүүлдэггүй, нийт хүн амын 22.3 хувь нь хөдөлгөөний хомсдолтой байна.



ИЛҮҮДЭЛ ЖИН БА АРТЕРИЙН ДАРАЛТ ИХСЭЛТ

Монгол Улсын 15-64 насны хүн амын дундах тархалт (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м ²)	25.9 (25.7-26.2)	25.3 (25-25.6)	26.6 (26.3-26.9)
Илүүдэл жинтэй ба таргалалттай хүн амын эзлэх хувь (БЖИ ≥ 25 кг/м ²)	54.4 (52.3-56.6)	49.0 (45.8-52.2)	59.9 (57.7-62.1)
а. Илүүдэл жинтэй хүн амын эзлэх хувь (БЖИ=25-29.9 кг/м ²)	34.8 (32.6-36.9)	33.9 (31.0-36.7)	35.7 (33.0-38.4)
б. Таргалалттай хүн амын эзлэх хувь (БЖИ ≥ 30 кг/м ²)	19.7 (18.0-21.5)	15.2 (13.3-17.0)	24.2 (21.5-27.0)
Төвийн таргалалттай (бэлхүүсний тойргийн хэмжээ: эр≥90 см, эм≥80 см) хүн амын эзлэх хувь	56.8 (54.0-59.6)	44.4 (40.8-47.9)	69.3 (66.6-71.9)
Артерийн даралт ихсэлт			
Систолийн артерийн даралтын дундаж хэмжээ (мм МУБ)	127 (125.9-128)	130 (128.7-131.4)	124.0 (122.7-125.3)
Диастолын артерийн даралтын дундаж хэмжээ (мм МУБ)	79.9 (79.3-80.4)	80.6 (79.7-81.5)	79.2 (78.5-79.9)
Артерийн даралт ихсэлттэй (САД ≥ 140 ба/эсвэл ДАД ≥ 90 мм МУБ) хүн амын эзлэх хувь	27.5 (25.6-29.4)	30.5 (27.4-33.7)	24.5 (27.4-33.7)
Артерийн даралт ихэссэн (САД ≥140 ба/эсвэл ДАД ≥ 90 мм МУБ) боловч даралт бууруулах эм хэрэглээгүй хүн амын эзлэх хувь	71.9 (66.7-76.5)	77.0 (70.8-82.2)	65.6 (58.7-71.9)

$$\text{БЖИ} = \text{Биеийн жин}_{(кг)} : (\text{биеийн өндөр}_{(м)} \times \text{биеийн өндөр}_{(м)})$$



Гол мэдээлэл:

- Илүүдэл жин ба таргалалттай 15-64 насны хүмүүсийн эзлэх хувь 2005 оноос хойш тасралтгүй нэмэгдэж, 2013 онд энэ насны 2 хүн тутмын 1 нь илүүдэл жин ба таргалалттай, 5 хүн тутмын нэг 1 нь таргалалттай буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байв.
- Артерийн даралт ихсэлтийн тархалт 2005, 2009 оны түвшингээс нэмэгдээгүй боловч, нийт хүн амын 27.5 хувь цусны даралт ихсэлттэй, даралт бууруулах эм хэрэглээгүй, цусны даралтаа хянадаггүй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдсэн байна.




ЦУСАН ДАХЬ ӨӨХ ТОС: ХОЛЕСТЕРИН БА ТРИГЛИЦЕРИД

МУ-ын 25-64 насны хүн амын дунд (95%ИХ)	Бүгд (N=6013)	Эрэгтэй (N=2719)	Эмэгтэй (N=3294)
Цусан дахь холестерин дундаж хэмжээ (ммол/л)	5.1 (5.0-5.2)	5.0 (4.9-5.1)	5.2 (5.1-5.3)
Цусан дахь холестерин хэмжээ ихэссэн (захын цусан дахь холестерин хэмжээ ≥ 5.0 ммол/л) хүн амын эзлэх хувь	61.9 (55.7-67.6)	56.0 (50.1-62.0)	67.3 (60.2-74.4)
Цусан дахь триглицерид дундаж хэмжээ (ммол/л)	1.3 (1.2-1.4)	1.4 (1.3-1.5)	1.2 (1.2-1.3)
Цусан дахь триглицерид хэмжээ ихэссэн (триглицерид хэмжээ ≥ 1.7 ммол/л) хүн амын эзлэх хувь	19.6 (15.7-23.5)	22.4 (17.1-27.6)	17.1 (13.3-20.9)
Цусан дахь бага нягттай липопротеин (БНЛ)-ы дундаж хэмжээ (ммол/л)	2.9 (2.8-2.9)	3.0 (2.9-3.0)	2.8 (2.7-2.8)
Цусан дахь БНЛ-ны хэмжээ ихэссэн (цусан дахь БНЛ-ны хэмжээ ≥ 3.0 ммол/л) хүн амын эзлэх хувь	42.5 (39.6-45.5)	47.5 (43.4-51.7)	37.7 (34.1-41.4)
Цусан дахь их нягттай липопротеин (ИНЛ)-ы дундаж хэмжээ (ммол/л)	1.3 (1.2-1.4)	1.2 (1.2-1.3)	1.4 (1.4-1.5)
Цусан дахь ИНЛ-ны хэмжээ буурсан (цусан дахь БНЛ-ны хэмжээ: Эрэгтэй < 1.03 ммол/л; Эмэгтэй < 1.29 ммол/л) хүн амын эзлэх хувь	-	30.9 (26.1-35.7)	36.2 (31.8-40.6)

Судасны хатуурал

Цусан дахь холестерин, ялангуяа БНЛ-ны хэмжээ ихсэхийн зэрэгцээ ИНЛ-ны хэмжээ буурах нь судасны хатуурал үүсэх эрсдэлийг илтгэдэг.



Гол мэдээлэл:

- Цусан дахь холестерин хэмжээ ихэссэн хүн амын эзлэх хувь 2013 онд 61.9 хувь, ялангуяа БНЛ-ны хэмжээ ихэссэн хүн амын үзүүлэлт 42.5 хувь байна. Өөрөөр хэлбэл 25-64 насны 10 хүн тутмын 4 нь судас хатуурах, улмаар зүрх судасны өвчнөөр өвчлөх эрсдэлтэй байна.
- Манай улсын 15-64 насны 3 хүн тутмын 1 нь цусан дахь ИНЛ-ны хэмжээ багатай байгаа нь зөв зохистой хооллох, ялангуяа өөх тосыг тохируулан хэрэглэх, эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөнийг тогтмол хийх шаардлагатайг илтгэж байв.





ХБӨ-ӨӨР ӨВЧЛӨХ ЭРСДЭЛИЙН ТАРХАЛТ

МУ-ын 15-64 насны хүн амын дунд (95%ИХ)	Бүгд (N=6013)	Эрэгтэй (N=2719)	Эмэгтэй (N=3294)
ХБӨ-ний нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн тархалт:			
Нийтлэг эрсдэлт хүчин зүйл (ЭЗХ) огт илрээгүй хүн амын эзлэх хувь	1 (0.6-1.4)	0.7 (0.3-1.0)	1.3 (0.7-1.9)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3-5 эрсдэл хавсран илэрсэн 15-44 насны хүн амын эзлэх хувь	28.3 (26.1-30.5)	35.2 (32.3-38.1)	21.6 (18.4-24.9)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3-5 эрсдэл хавсран илэрсэн 45-64 насны хүн амын эзлэх хувь	53.2 (49.8-56.5)	59.7 (55.6-63.7)	46.2 (41.3-51.1)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3-5 эрсдэл хавсран илэрсэн 15-64 насны хүн амын эзлэх хувь	36.9 (34.6-39.1)	43.9 (41.3-46.5)	29.8 (26.7-33.0)

ХБӨ-ний нийтлэг эрсдэлт хүчин зүйл

Өдөр бүр тамхи татах, хоногт 5 нэгж (400 г)-ээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэх, хөдөлгөөний хомсдол, илүүдэл жин эсвэл таргалалт, артерийн даралт ихсэлтийг ХБӨ үүсгэх нийтлэг 5 эрсдэлт хүчин зүйлс хэмээн нэрлэдэг.



Гол мэдээлэл:

- Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн аль нэг нь огт илрээгүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын эзлэх хувь дөнгөж 1 хувь, харин нийт хүн амын 36.9 хувь нь ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй буюу 3-5 эрсдэл хавсран илэрсэн байна.
- Манай улсын 45-64 насны хүмүүсийн талаас илүү буюу 53.2 хувь ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй байв. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй 15-44 насны хүмүүсийн эзлэх хувь 2013 онд эрс нэмэгдэж, 28.2 хувьд хүрсэн нь залуучуудын дунд ХБӨ-өөс сэргийлэх, хянах арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатайг илтгэж байна.




ЧИХРИЙН ШИЖИН

МУ-ын 25-64 насны хүн амын дунд (95%ИХ)	Бүгд (N=6013)	Эрэгтэй (N=2719)	Эмэгтэй (N=3294)
Өлөн үеийн цусан дахь глюкозын дундаж хэмжээ (ммол/л)	5.0 (4.8-5.1)	5.0 (4.8-5.2)	4.9 (4.8-5.0)
Цусан дахь глюкозын хэмжээ ихсэх эрсдэлтэй (глюкозын хэмжээ 5.6-6.0 ммол/л) хүн амын эзлэх хувь	8.3 (6.0-11.5)	10.0 (6.0-14.0)	6.8 (4.3-9.3)
Чихрийн шижин (глюкозын хэмжээ ≥ 6.1 ммол/л болон глюкоз бууруулах эм хэрэглэдэг)-тэй хүн амын эзлэх хувь	6.9 (4.3-11)	7.6 (2.8-12.3)	6.3 (3.8-8.8)

Чихрийн шижин

Захын цусан дахь сахар буюу глюкозын хэмжээ 5.6-6.0 ммол/л байвал глюкозын хэмжээ ихсэх эрсдэлтэй буюу чихрийн шижингээр өвчлөх эрсдэлтэй байна гэж үнэлдэг. Харин цусан дахь глюкозын хэмжээ 6.1 ммол/л ба түүнээс их, глюкоз бууруулах эм хэрэглэж байгаа тохиолдолд чихрийн шижинтэй хэмээн үнэлэв.



Гол мэдээлэл:



- МУ-ын 25-64 насны хүмүүсийн өлөн үеийн цусан дахь сахар буюу глюкозын дундаж хэмжээ 2005 оны түвшингээс төдийлэн өөрчлөгдөөгүй, 5.0 ммол/л байна.
- Өлөн үеийн цусан дахь глюкозын хэмжээ ихсэх эрсдэлтэй буюу чихрийн шижингээр өвчлөх эрсдэлтэй хүмүүсийн эзлэх хувь 8.3 хувь, 25-64 насны хүмүүсийн 6.9 хувь нь чихрийн шижинтэй байв.



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН, ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААН, ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН ШАТАЛСАН СУДАЛГАА, МОНГОЛ УЛС-2013 ОН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

ОСОЛ ГЭМТЭЛ БА ХҮЧИРХИЙЛЭЛ

МУ-ын 15-64 насны хүн амын дундах тархалтын түвшин (95%ИХ)	Бүгд (N=6013)	Эрэгтэй (N=2719)	Эмэгтэй (N=3294)
Шатлал 1. Зам тээврийн осол (ЗТО)			
Сүүлийн 12 сарын хугацаанд ЗТО-д орсон хүн амын эзлэх хувь	3.4 (2.6-4.3)	4.9 (3.7-6.4)	1.8 (1.3-2.6)
Сүүлийн 12 сарын хугацаанд ЗТО-ын бус шалтгаанаар хүнд гэмтэж, эмнэлгийн тусламж авсан хүн амын эзлэх хувь	6.9 (6.1-7.9)	8.8 (7.3-10.6)	5.1 (4.1-6.2)
Тээврийн хэрэгсэл жолоодох эсвэл зорчихдоо суудлын даруулга хэрэглэдэггүй хүн амын эзлэх хувь	75.4 (72.1-78.5)	70.1 (66.1-73.8)	80.7 (77.1-84.3)
Сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундаа хэрэглэсэн жолоочийн тээврийн хэрэгсэлд суусан хүн амын эзлэх хувь	5.5 (4.2-7.1)	7.6 (5.8-9.8)	3.4 (2.3-5.0)
Мотоцикл, дугуйгаар зорчих эсвэл жолоодохдоо хамгаалалтын дуулга хэрэглэдэггүй хүн амын эзлэх хувь	86.3 (79.0-91.4)	82.4 (72.2-89.3)	92.3 (87.9-95.2)
Шатлал 1. Хүчирхийлэл			
Хүчирхийллийн улмаас хүндээр гэмтэж, эмнэлгийн тусламж авсан хүн амын эзлэх хувь	6.0 (4.5-8.2)	6.5 (3.7-11.1)	5.8 (3.9-8.6)
Хүүхэд насандаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүн амын эзлэх хувь	48.2 (45.0-51.4)	55.8 (52.0-59.6)	40.7 (37.4-44.1)



Гол мэдээлэл:



- МУ-ын 15-64 насны 4 хүн тутмын 3 нь тээврийн хэрэгсэл жолоодох эсвэл зорчихдоо суудлын даруулгаа байнга хэрэглэдэггүй эсвэл "заримдаа" хэрэглэдэг, 10 хүн тутмын 9 орчим (86.3%) нь мотоцикл, дугуйгаар зорчих эсвэл жолоодохдоо хамгаалалтын малгай байнга хэрэглэдэггүй байна.
- Нийт хүн амын 3.4 хувь нь ЗТО-д өртсөн, 5.5 хувь согтууруулах ундаа хэрэглэсэн жолоочийн тээврийн хэрэгсэлд суусан нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох тохиолдол оршсоор байгааг илтгэж байв.
- Судалгааны хүн амын 6 хувь нь хүчирхийлэлд өртөж, эмнэлгийн тусламж авсан ба хүүхдийн эсрэг бие махбодын хүчирхийлэлд 2 хүн тутмын 1 нь өртсөн байна.



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН, ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААН, ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН ШАТАЛСАН СУДАЛГАА, МОНГОЛ УЛС-2013 ОН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Монгол Улсын 15-64 насны хүн амын дунд (95% ИХ)	Бүгд (N=6013)	Эрэгтэй (N=2719)	Эмэгтэй (N=3294)
Шүдэлбэр буюу хиймэл шүд хэрэглэдэг хүн амын эзлэх хувь	29.9 (27.5-32.4)	26.2 (23.7-28.9)	33.6 (30.6-36.7)
Сүүлийн 12 сард шүдний эмчид үзүүлсэн хүн амын эзлэх хувь	40.5 (37.9-43.1)	46.5 (42.6-50.4)	34.5 (31.3-37.6)
Хоногт 2-оос доошгүй удаа шүдээ угаадаг хүн амын эзлэх хувь	56.6 (53.5-59.7)	43.8 (39.4-48.1)	69.2 (66.6-71.9)



Гол мэдээлэл

- Судалгааны хүн амын 73.7 хувь нь 20 ба түүнээс олон шүдтэй, 2.1 хувь нь огт шүдгүй байв. Нас ахих тусам шүдний тоо цөөрч, шүдгүйдлийн хувь нэмэгдэж байгаа бөгөөд нийт хүмүүсийн 29.9 хувь нь шүдэлбэр буюу хиймэл шүд хэрэглэж байна.
- Сүүлийн 12 сарын хугацаанд хүн амын 40.5 хувь нь эмчилгээ, давтан үзлэх хийлгэх, шүд өвдсөний улмаас шүдний эмчид хандсан байна. Эмчилгээ, давтан үзлэг хийлгэх зорилгоор шүдний эмчид хандсан хүмүүсийн эзлэх хувь хотод болон эмэгтэйчүүдийн дунд харьцангуй илүү байгаа бол шүд өвдсөн үед шүдний эмчид хандах байдал хөдөөд илүү байв.
- Нийт хүн амын 94.1 хувь нь шүдээ угаадаг, 56.6 хувь нь өдөрт 2 ба түүнээс олон удаа шүдээ угаадаг ба нас ахих тутам шүд угаах дадал буурч байна. Шүдээ тогтмол угаах дадал эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс харьцангуй илүү байв.